



“Монголын хөрөнгийн бирж” ХК-ийн олон нийтээс татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалтын тайлан

/2024 оны 12 сарын 31-ний байдлаар/

"Монголын хөрөнгийн бирж" ХК нь Улсын Их Хурал, Засгийн газрын холбогдох шийдвэрийн дагуу 2022 оны 12 дугаар сард нэмэлт хувьцаагаа олон нийтэд санал болгон нээлттэй арилжиж нийт 11.9 тэрбум төгрөгийг татан төвлөрүүлсэн билээ.

Татан төвлөрүүлэх хөрөнгийн зарцуулалтын талаар үнэт цаасны танилцуулгад тодорхой тусгасан бөгөөд компанийн дунд хугацааны бизнес төлөвлөгөөний дагуу татан төвлөрүүлсэн хөрөнгийг дараах байдлаар зарцуулахаар төлөвлөсөн болно.

Хүснэгт №1. Татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалтын төлөвлөгөө

№	Татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалтын төлөвлөгөө	
1	Арилжааны систем сайжруулалт	63.7%
2	Мэдээлэл технологийн аюулгүй байдал	10.7%
3	Дотоод үйл ажиллагааны цахимжуулалт	6.1%
4	Хөрөнгийн зах зээлийн сургалт үйлчилгээ, мэдээллийн хүртээмжтэй байдлыг нэмэгдүүлэх төв бий болгох	19.5%
Нийт		100.0%

Компани 2024 онд нийт татан төвлөрүүлсэн хөрөнгөөс 5.4 тэрбум төгрөгийн зарцуулалт хийхээр төлөвлөсөн бөгөөд үүнд:

- Арилжааны дэд бүтэц болох МIТ системийн арилжааны болон хяналтын программ хангамжийн шинэчлэл, түүхий эд болон деривативын арилжааны модуль, үйлдлийн системийн шинэчлэл сайжруулалтад нийт 1.9 тэрбум төгрөг;
- Мэдээлэл технологийн аюулгүй байдлыг хангах зорилгоор серверийн ерөөний стандартжуулалт, шинэчлэлийн ажил болон дотоод үйл ажиллагааны автоматжуулалтад нийт 1.3 тэрбум төгрөг;
- Хөрөнгийн зах зээлийн сургалт, үйлчилгээ, мэдээллийн хүртээмжтэй байдлыг нэмэгдүүлэх төв бий болгоход 2.2 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтыг тус тус хийхээр төлөвлөсөн болно.



Тайлант хугацаанд Арилжааны систем сайжруулалтын ажилд 631.7 сая төгрөг, Хөрөнгийн зах зээлийн сургалт үйлчилгээ, мэдээллийн хүртээмжтэй байдлыг нэмэгдүүлэх төв бий болгох зорилгоор барилга байгууламжийн дотоод зохион байгуулалтын засварын ажилд 2,103.2 сая төгрөг, Серверийн өрөөний стандартжуулалтын ажилд 981.1 сая төгрөг, Дотоод үйл ажиллагааны цахимжуулалтад 38.5 сая төгрөг, нийт 3,754.7 сая төгрөгийн хөрөнгө оруулалтыг “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн дагуу зохион байгуулж, хэрэгжүүлэн ажилласан байна.

Хүснэгт№2.Татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалтын тайлан 2024 он /мян.төг/

№	Бараа, ажил үйлчилгээний нэрс	Төлөвлөгөө		2024 он		
				Төлөвлөгөө		Гүйцэтгэл
		Дүн	Хувь	Дүн	Дүн	Хувь
1	Арилжааны системийн сайжруулалт	7,590,339.3	64%	1,939,636.3	631,673.0	8%
2	Мэдээлэл технологийн аюулгүй байдал	1,274,986.4	11%	1,202,743.7	981,365.6	77%
3	Дотоод үйл ажиллагааны цахимжуулалт	726,861.4	6%	48,400.0	38,530.0	5%
4	Хөрөнгийн зах зээлийн сургалт үйлчилгээ, мэдээллийн хүртээмжтэй байдлыг нэмэгдүүлэх төв бий болгох зорилгоор барилга байгууламжийн дотоод зохион байгуулалтын өөрчлөлтөд оруулах хөрөнгө оруулалт	2,323,573.3	20%	2,244,155.9	2,103,185.0	91%
Нийт		11,915,760.3	100%	5,434,935.9	3,754,753.6	32%

Компани нэмэлт хувьцаагаа олон нийтэд санал болгон нээлттэй арилжин нийт 11.9 тэрбум төгрөгийг татан төвлөрүүлснээс хойш 2023-2024 оны хугацаанд нийт зарцуулсан зарцуулалтын задаргааг доорх хүснэгтээс харна уу.

Хүснэгт№3.Татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалтын тайлан 2023-2024 /мян.төг/

№	Бараа, ажил үйлчилгээний нэрс	Төлөвлөгөө		2023 оны гүйцэтгэл	2024 оны гүйцэтгэл	Нийт гүйцэтгэл	
		Дүн	Хувь			Дүн	Хувь
1	Арилжааны системийн сайжруулалт	7,590,339.3	64%	1,264,997.0	631,673.0	1,896,670.0	25%
2	Мэдээлэл технологийн аюулгүй байдал	1,274,986.4	11%	65,896.3	981,365.6	1,047,262.0	82%
3	Дотоод үйл ажиллагааны цахимжуулалт	726,861.4	6%	76,801.5	38,530.0	115,331.5	16%
4	Хөрөнгийн зах зээлийн сургалт үйлчилгээ, мэдээллийн хүртээмжтэй байдлыг нэмэгдүүлэх төв бий болгох зорилгоор барилга байгууламжийн дотоод зохион байгуулалтын өөрчлөлтөд оруулах хөрөнгө оруулалт	2,323,573.3	20%	79,417.3	2,103,185.0	2,182,602.2	94%
Нийт		11,915,760.3	100%	1,487,112.0	3,754,753.6	5,241,865.6	44%



Татан төвлөрүүлсэн хөрөнгийн төлөвлөгөөнд тусгагдсан бараа, ажил, үйлчилгээг худалдан авах ажиллагааг тухайн жил бүр компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн батлуулж, холбогдох төр захиргааны байгууллагад хүргүүлэн “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийг мөрдөн, компанийн үнэт цаасны танилцуулгад танилцуулсан зориулалтын дагуу үе шаттайгаар хэрэгжүүлж байгаа болно.